

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244807

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН”-Ы “ᠠᠯᠠᠭ” (iloᠭa) ГЭХ
ҮГИЙГ ШИНЖЛЭХ НЬ

Урианхажин Мөнгөнцэцэг
Бүрэнбат

Товч агуулга: “Монголын нууц товчоон”-д “ᠠᠯᠠᠭ” илᠠᠭa” язгуурт үг §174-т “ᠠᠯᠠᠭᠠᠳᠠᠬᠤ iloyadqu” ба “ᠠᠯᠠᠭᠠᠳᠤ iloyadba” хэмээн хоёр удаа, §188-д “ᠠᠯᠠᠭᠠᠳᠤᠵᠢ iloyatuju” хэмээн нэг удаа, нийт гурван удаа хэрэглэгдэв. Тус гурван үгийг эрдэмтэн судлаачид адил бусаар тайлбарлаж байх бөгөөд энэ гурван үгийн язгуурыг илоо гэх шавжтай холбон тайлбарласан үзэлт харагдахгүй. Эрдэмтэн судлаачдын §174-ын “iloyadqu” ба “iloyadba” гэх үгийг “халдах”, “дайлах”, “тэмцэх” гэх мэтээр тайлбарлаж, §188-ын “iloyatuju” гэх үгийг олонх нь “ᠠᠯᠠᠭ” илᠠᠭa” язгуураар орчуулах буюу тайлбарлаж буй. Бид “iloyā” язгуурт үгсийг “iloy-a” гэх шавжтай холбон тайлбарлаж, тус үгийн хоёрдугаар үеийн эгшиг бол дөрөвдүгээр эгшиг мөн гэж үзэж, тус үг §188 -д үндсэн утгаар, §174-д шилжсэн утгаар хэрэглэгдэв хэмээн үзэж буй. Үүний улмаар бид “iloyā” язгуурт үгийн утга, бичлэг, холбогдох хэл зүйн учир зэргийг шинжлээд эртний сурвалж бичигт гардаг “ᠠᠯᠠᠭᠠᠳᠤᠵᠢ ilayuyusan” “ᠠᠯᠠᠭᠠᠳᠤ ilayuyūci” зэрэг үгс ба хорчин нутгийн аялгууны “ᠠᠯᠠᠭᠠᠳᠤ iloyāqu [jɔlɔ:x]” гэх үгийн язгуур нь мөн ч тус үг болохыг нотлон өгүүлэв.

Түлхүүр үг: “Монголын нууц товчоон”, iloyā, “i”-ийн нугарал, нэр ба үйлийн хос язгуурт үг

“ᠠᠯᠠᠭ” илᠠᠭa” язгуурт үг “Монголын нууц товчоон”-д хоёр зүйлд гурван хэлбэрээр тэмдэглэгджээ. Нэг тэмдэглэлийг олонх нь “ilay-a ᠠᠯᠠᠭ”-тай холбон тайлбарласныг бид хүлээн зөвшөөрмөөргүй байна. Тус өгүүлэлд бид энэ гурван “iloyā” язгуурт үгийг “iloy-a” гэх шавжтай холбон тайлбарлаж, тус үгийн утга, бичлэг, дуудлага ба холбогдол бүхий хэл зүйн учир ёсыг шинжлэхийг зорьж буй.

Нэг. “iloyā” язгуурт үгийн тэмдэглэл ба эрдэмтдийн тайлбар буюу орчуулга: “Монголын нууц товчоон”-д “iloyā” гэх үг хоёр зүйлд тэмдэглэгдэж буй. Үүний нэг нь §174-ийн “王_中罕可兀邊 桑古迷 兀出馬阿兒 昂格思格_ 合察_ 兀納塔刺 中合 荅周 迭額_列 亦訥 額客額_兒抽 田迭 鳴訖列主為 喜魯_ 中合 忽由 篋圖突_兒 喜魯_ 中合 羅 中合 忽由篋圖突_兒 中合 渾 孛 命 中合 亦_蘭 可兀訥米訥 中合 察_兒途_兒 中合 荅阿孫 中合 荅兀勒罷(Ong_qan köü-ben Senggüm-i ućuma-ar enggesge qačar unatala qaqdaju de`ere in-u eke`erčü tende ügülejü`üi <hiluqatquyu metü-tür hiluqatba. qalquyu metü-tür qalqun bolun qayıran köü`n-ü min-u qačar-tür qada`asun qada`ulbai.)”(Kuribayashi2001:272) гэх тэмдэглэл, нөгөө нь §188-ын “桑昆的的_ 撒_ 中合 命 涅坤 兀速納 兀祿 幹_ 樂 中合

荅温 約^{舌兒}赤周 川^勒-突^{舌兒} 幹^{舌羅}周 兀速^{舌兒}中合^舌中忽刺^楊 𐰽喜魯阿禿周 擺亦^中忽泥 桑昆 保兀周 馬^舌里牙主兀(Senggüm Didik_saqal-un Nekün_usun-a ülü oron qada'un yorčijü Čöl-tür oroju usurqarun qulat hilu'atuju bayuqun-i Senggüm bawuju mariyaju'u.)” (Kuribayashi2001:316) гэх тэмдэглэл болно. §174-ийн “^{ᠠᠯᠠᠭᠠᠳᠤ} iloyadqu” ба “^{ᠠᠯᠠᠭᠠᠳᠤᠪᠠ} iloyadba”-гийн хятад галиглал нь “喜魯^中合^楊 中忽” ба “喜魯^中合^楊 罷” гэж, §188-ын “iloyatuju ^{ᠠᠯᠠᠭᠠᠳᠤ}”-гийн хятад галиглал нь “𐰽喜魯阿禿周” гэж байхаас үзвэл, тус гурван үгийн язгуурын дуудлага нь ижил байна. Тус гурван үгийн эхэн дэх “h” бол дундад эртний монгол хэлний үгийн эхний эгшгийн өмнө түгээмэл тохиолддог “h” мөн, үүний тухай өгүүллийн гуравдугаар хэсэгт өгүүлнэ.

“Монголын нууц товчоон”-ы “холад илогадужу байхуныг Сэнгүм бууж мариажугу” гэх тэмдэглэлийн “iloyatuju” гэх үгийг олонх эрдэмтэд “ялаа” гэх үгтэй холбон тайлбарлах буюу орчин цагийн монгол хэлэнд хөрвүүлэн буулгажээ. Уултай Ардаажаваас “ ... холад ялаанд илагадажу шахалдан байхыг үзэж ... ” (2010:157) хэмээн орчин цагийн монгол хэлэнд сийрүүлж, Ц.Дамдинсүрэн ба тайчууд Мансан тус тус “ ... хулан ялаархан зогсож байхыг үзээд ... ” (2007:161) ба “ хэсэг хулан ялаархан зогсож байхыг үзээд ... ” (2007:188) хэмээн, Ш.Чоймаа (2006:128) ба С.Мөнхсайхан (2024:144) бүр “хулад ялаатаж байхуныг” хэмээн орчин цагийн монгол хэлэнд хөрвүүлэн буулгажээ. §174-ийн “iloya” язгуурт үгийг олонх эрдэмтэд хажуугийн орчуулга буюу ерөнхий утгыг нь үндэслэн орчуулан тайлбарлажээ. Элдэндэй, Ардаажаваас “халдах” (1986:509) хэмээн хажуугийн орчуулгын тайлбарыг баримталж, Ц.Дамдинсүрэн “хөндлөнгийн хүнийг хөнөөх хэмээгээд хөөрхий биеэ хөсөрдүүлэв чи” (2007:141) хэмээн, тайчууд Мансан “дайлж үл болох дайсантай дайлалдаж” (2007:168) хэмээн, Тэгшдүүрэн, хошууд Цэнгэл, Урангуа “тэмцэх мэтэстэй тэмцэлдэв” (2020:174) хэмээн утгачлан орчуулцгааж, С.Мөнхсайхан “Илагтахуй уу мэтэд илагтав ” гэж хөрвүүлэн буулгаж, Ш.Чоймаа “Ялагдахуй л мэтэд ялагдав ”(2024:127) хэмээн буулгаж, “үл ялагдах мэтэд ялагдав” (2006:113-114) гэж тайлбарлав.Жүгдэрийн Лувсандорж “Нялгадаж болшгүйг нялгадах гээд нялгадуулав”(2014:63) гэж хөрвүүлэн буулгаж, “нялж чадахгүй юмыг нялах гэж байгаад өөрөө нялуулав”(2014:361) гэж тайлбарлав. Англи орчуулгын хувьд, Кливез “At [a time] in which it seemeth [that we ought to have asked ourselves,]”shall we stir [him] up?” we stirred [him] up.”(1982:100) хэмээн англичилж, Рахевилз “when it would have been better not to stir him up,we did stir him up.” (2015:88) хэмээн, Онон Өргөнгөө “should you have stirred those [things] that you stirred?” (2001:150) хэмээн англичилжээ. Хятад орчуулгын хувьд, Загчидцэцэн “招惹那不该招惹的。” (1979:226) хэмээн хятадчилж, Иүй Да Жиюүн “招惹那不该招惹的” (2014:285) хэмээн хятадчилжээ. Япон орчуулгын хувьд, Мүраками Масазүкү “悩ますべからざるが如きを悩ましぬ” (1976:144) хэмээн япончилж, Озава Шигео “争う如き者にか争いたる” (1997:226) хэмээн япончилжээ. Эдгээр бол бүр хятад галиглал буюу ерөнхий утгыг нь үндэслэсэн орчуулга буюу тайлбар болно. Тус үгийн язгуурыг шавжтай холбосон тайлбар буюу орчуулга харагдсангүй.

Хоёр. “iloᠢᠶᠠ” гэх үгийн утга: 2023 оны 7 дугаар сард Өвөр Монголын Их Сургуульд болсон “Өвөр Монголын Их Сургуулийн хоёрдугаар удаагийн монгол сурвалж бичгийн олон улсын эрдэм шинжилгээний хурал”-д Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн Хурцбилэг судлаач “Ордос нутагт морины биеийг салалгүй дагаж, цусыг нь сордог шумуулыг илоо ( буюу ) [jɔlɔ:] гэдэг. Хятадаар 虻 гэдэг шиг”¹ гэх мэдээ зангийг бидэнд хангав. Энэ нь “Монголын нууц товчоон”-ы §188-ын “iloᠢᠶᠠtuᠢᠵᠢ” гэх үгийн хажуугийн орчуулга “被虻咬著” гэдэгтэй яв цав тохиролцож буй. Тус үгийг англиар орчуулсан талаар Кливез ба Рахевилз “gadfly” хэмээн орчуулсан нь **ЭНЭ** үгний хажуугийн хятад орчуулгатай тохиролцож бий.

Амьд бодисын нэрийдлийн хувьд, илоо ба гэрийн ялаа бол хос далавчит шавжийн(Diptera) ялгалын доторх адил бус салааны хоёр зүйлийн шавж мөн. Илоо (gadfly) бол сонын салаанд (Tabanidae) харьяалагдаж, эрэгчин нь цэцгийн балыг сорж эмэгчин нь үхэр малын цусыг сорж амьдардаг. Толь бичиг ба олонх нутагт хөх түрүү ба соно гэдэг шавж ийн нэрийдэл түгээмэл байж, илоо гэдэг нэрийдэл одоо зөвхөн ордос нутагт л үлдэж буй. Гэрийн ялаа бол ялааны салаанд (Muscidae) харьяалагдаж, ялзарсан органик бодис ба цэцгийн бал зэргийг идэж амьдардаг, хүн амьтны цусыг сорж чадахгүй.

“Монголын нууц товчоон”-ы §188-ын “iloᠢᠶᠠtuᠢᠵᠢ” гэх үг нь илоо гэх шавжид зуугдах, цусаа сорогдох буюу илоо гэх шавжийн халдлагад учрах гэх үндсэн утгатай байж, §174-ийн “iloᠢᠶᠠdqu” ба “iloᠢᠶᠠdba” бол “iloᠢᠶᠠ-a” язгуураас үүссэн шилжсэн утгат үг болно хэмээн бид үзэж буй. “da/ta, du/tu, d” гурван дагавар бол нэр үгээс үйл үг үүсгэх дагавар болно. Тус гурван дагаврыг “жинхэнэ нэрд залгаж, тухайн хэрэг бодистой холбогдол бүхий үйл хөдөлгөөн (хэрэг бодисыг атгаж барих, хэрэглэх, түүнийг үүсгэх)-ийг илтгэх үйл үгийг бүтээнэ” (Čenggeltei,1999:503). “ чулууд,  үнэрт,  жолоод” зэрэг бол тус гурван дагаврыг хэрэглэж үйл үг бүтээсэн үгс мөн. “Монголын нууц товчоон” дахь “iloᠢᠶᠠtu” ба “iloᠢᠶᠠd” бол “iloᠢᠶᠠ-a” гэх нэр язгуурт “tu” ба “d” дагаврыг залгаж бүтсэн үйл үг болно. Иймээс “iloᠢᠶᠠtu” ба “iloᠢᠶᠠd” хоёр үгийн хэл зүйн утга нь адил хэмээн бид үзэж байна. Жүгдэрийн Лувсандорж §188-ын “iloᠢᠶᠠtuᠢᠵᠢ” гэх үгийг “iloᠢᠶᠠ” үндсэнд “tu” дагавар залгаж бүтжээ(2014:385) гэж үзсэн нь бидэнтэй үзэлт адилаартар боловч тус үгийг “нялгадаж” гэж тайлбарласан нь бидэнтэй үзэлт ондоо байна. Бидний үзэхээр тус үг бол “iloᠢᠶᠠ” язгуурт “tu” дагавар залгаж бүтсэн илоо гэх шавжид цусаа сорогдох гэх үндсэн утгат үг байж, §174-ийн “iloᠢᠶᠠdqu” ба “iloᠢᠶᠠdba” бол “iloᠢᠶᠠ” язгуураас үүссэн шилжсэн утгат үг мөн.

“iloᠢᠶᠠdqu” гэх үгийн шилжсэн утгыг тайлбарлахаас өмнө “iloᠢᠶᠠ-a” гэх шавжийн тухай товч танилцуулья. Ордос нутгийн малчин Алтанбаатарын ярихаар “илоо[iloᠢᠶᠠ-a] сүрэг сүргээрээ морийг хатгадаг, голдуу морины толгойтой ноцолддог. Илоо-нд хатгагдсан морь зовж сандран бачимдахдаа хөдөө гадаа байвал хөрвөдөг, шон дээр байвал шон баганыг шөргөөнө, дэл сүүлээрээ шарвана. Зарим айлын ядар дорой морь нь ялаархаад үхэж байсныг ч сонсож

¹ Тус өгүүллийг бичихэд түлхүүр мэт тайлбар болсон энэ мэдээ зангийг хангасан Хурцбилэг судлаачид гүн талархал дэвшүүлж байна.

өнгөрөв. Илоо заримдаа хүнийг ч бас хатгадаг”². Үүнээс үзэхэд, илоо гэх шавж морь мал буюу хүний цусыг сорж, амь тэжээдэг, заримдаа ядар дорой моринны амийг нь хороож дийлнэ. Гэвч бас заримдаа хэцүү морь буюу хүнийг хатгавал амиа ч алдах боломж бий. Иймээс хэцүү морь буюу хүн бол илоо-ны халдаж болохгүй хэцүү этгээд болно. “Монголын нууц товчоон”-ы §174 -ийн “*iloγadqu uu metü dür iloγadba*” гэдэг бол илоо-гоор Ван ханыхныг зүйрлэсэн, хэцүү этгээдээр Чингис хааныхныг зүйрлэсэн “*iloγ-a*” язгуурт үгийн шилжсэн утгыг хэрэглэсэн өгүүлбэр болно. Ван ханы хэлсэн “*iloγadqu uu metü dür iloγadba. qalqu metü dür qalqun bolun qayiran köbegün-ü minu qačar tur qadaγasun qadaγulba*” гэх үгийн утга бол “илоодож болох шиг хүмүүстэй илоодов уу ?, Халдаж болох шиг хүмүүстэй халдав уу ? Үүнээс болж хайран хөвгүүний хацар тур хадаасан хадуулав” болно. Үүнд “уу” бол асуух сул үг болно. Энд буцаан асуух өгүүлбэрийн утгыг илтгэж байна. Тодорхойлуштай нь, дундад эртний монгол хэлний “уу”-гийн байр нь орчин цагийн монгол хэлнийхтэй адилгүй тохиолдолтой байжээ. Энэ бол дундад эртний монгол хэлний бас нэг өвөрмөц онцлог байгаа юм. “*iloγadqu uu metü dür iloγadba*” гэх өгүүлбэрийг одоогийнхоор бол “илоодож болохгүй хүмүүстэй илоодов” гэж ойлгоход болох юм. Эрдэмтдийн орчуулга буюу тайлбар дотроос тайчууд Мансангийн “дайлж үл болох дайсантай дайлалдаж”(2007:168) гэх орчуулга ба Озава Шигеогийн “ ‘Тэмцэлдэх ёстой этгээдтэй тэмцэлдэв үү? Дийлмээргүй’, ‘халдах ёстой этгээдтэй халдав уу? Дийлмээргүй’ гэсэн утгатай юм. Дөхмөөр хэлбэл, ‘тэмцэх ёстой этгээд биш байсан хүнтэй тэмцэв. Халдах ёстой биш байсан хүнтэй халдав’ гэсэн утгатай юм” (1997:248-249) гэх тайлбар нь уул өгүүлбэрийн утгыг нэлээд онож чаджээ.

Алимгүй жижиг хорхой шавж ч гэсэн тэдгээрийн биеэс хол том хүн буюу морь малыг тарчлааж зовоодог гэдэг эртний монголчуудын хувьсангуй бодисч үзлийн танилт “Монголын нууц товчоон”-ы §174-ийн “*iloγa*” язгуурт үгийн шилжсэн утгат хэрэглээнд тусгагдаж байна. Үүнээс гадна, эртний монголчуудын иймэрхүү танилт §201-ийн Жамухын хэлсэн “...迭列該 額朶額 別連 孛魯 三突 舌兒 那可扯周 牙温 土撒 孛^勒 忽 必 捫荅 安荅因 中合^舌刺 雪你訥 沼兀敦-突 舌兒 赤訥 幹^舌羅中忽 必 格格延 兀都^舌侖 薛^楊 乞^勒 赤訥 勺巴阿^中忽 必 札^中合 因 赤訥 孛額孫 札興温 赤訥 幹^舌魯格孫 孛^勒 忽 必 ... delegei edö’e belen boluqsan-tur nököcejü ya’un tusa bolqu bi. munda anda-yin qara sönin-ü jewüdün-tür čin-u oroqu bi. gege’en üdür-ün setkil čin-u joba’aqu bi. jaqa-yin čin-u bö’esün jahing-un čin-u örgesün bolqu bi. ...)”(Kuribayashi2001:378) гэх үгэнд ч тусгагдаж буй. Морь малыг дарлаж зовоодог шавжид ялаанаас гадна хэдгэнэ гэж бас байдаг. Өнгөрсөнд хэдгэнэтсэн үхэр мал оодгоноод эзнийхээ эд хогшил буюу амь насанд нь хохирол учруулж байсан явдал гарч байжээ. Гэвч одоо үхэр малд янз бүрийн хорхой алах эмийг хэрэглэдгээс болж, хэдгэнийн авгалдай нь морь (үхэр) малын арьсан доороос цоорч гарах “гуур цоорох” үзэгдэл дэмий харагдахгүй болсноос гадна, хүлшний үхэр, морь цөөрснөөс морь буюу үхэр хэдгэнэтээд тэргээ хөглүүлж хөрвүүлэх үзэгдэл дэмий харагдахаа болив. Малчин Алтанбаатарын

² Ойгуд Намсрайн сурвалжилгаар дамжин Хангин хошууны Дугуйтал балгасны Тариан гол хамааралтын зөвлөлийн Баянцэнгэл гацааны малчин Алтанбаатараас илооны тухай тус мэдээ зангийг олов. Намсрай ба Алтанбаатар гуайд гүн талархал дэвшүүлж байна.

хэлэхээр илоо ч бас одоо дэмий харагдахаа больсон гэнэ. Тус өгүүллийг бичих явцад Ордос нутагт “iloᠣᠭа” язгуурын шилжсэн утгыг одоо ч гэсэн хүнд хэрэглэж байхыг олж мэдэв. Ордосын Үүшин хошууны Баянжаргал настны хэлэхээр “илоо бол хөх түрүүнээс жижиг, хөх түрүү бол хөх толгойтой, илоо бол хар толгойтой, илоо голдуу морины хоншоор ба цавийг нь хатгадаг. Морь өвдөхдөө цавчлаад тогтворгүй болдог. Үүнээс улируулаад сэтгэл санаа тогтворгүй эсхүл, тогтворгүй зантай хүнийг бас илоотсон хүн гэдэг”³ Энэ бол “iloᠣᠭа” язгуурт үгийн бас нэгэн шилжсэн утгатай үг болно. “Монголын нууц товчоон”-ы §174-ийн “iloᠣᠭадqu uи metü dūr iloᠣᠭадba” бол “илоо мэт дайрах” гэх утгатай үйлдэгчийн харааст үг байхад Ордос нутагт хэлдэг “илоотсон хүн” гэдэг бол илоонд дайрагдсаны дараах үр дүнг заасан үйлдэгдэгчийн харааст үг болно. Иймээс илоо язгуурын шилжсэн утгатай хэрэглээ нэгээр зогсохгүй гэдгийг мэдэж болно. Монгол хэлний түүхэн хөгжлийн явцад тус язгуурын үгэнд бусад хувиралт үүссэн эсэхийг хайн сүвэгчлэхэд хорчин нутгийн аялгуу дахь “iloᠣᠭаqu-илоох ” гэх үг аргагүй санаанд орж ирнэ. Тус үг бол хорчин нутгийн аялгуунд тун идэвхтэй хэрэглэгддэг үг мөн. “Монголын нууц товчоон”-ы “iloᠣᠭа” гэх үг бол хорчин нутгийн аялгууны “iloᠣᠭаqu ᠬᠣᠯᠠᠭᠠᠨ [jɔlɔ:x]” гэх үгийн язгуур болох боломжийг дөрөвдүгээр агуулгад өгүүлнэ.

Гурав. “iloᠣᠭа-” гэх үгийн бичлэг: Нэг талаар, “iloᠣᠭа” язгуурт үгийн утга учрыг улам нэг алхам шинжлэх зорилгоор, нөгөө талаар, тус үгийг “ilaᠭ-a” гэх нэр үг ба “ila” язгуурт үйл үгтэй тодорхой ялгах шаардлагаар тус үгийн бичлэгийг өгүүлэн тодорхойлъё.

1. Нэгдүгээр үеийн бичлэг. “Монголын нууц товчоон”-ы “iloᠣᠭа” язгуурт үгсийн нэгдүгээр үеийн хятад галиглалд “喜” үсгийг хэрэглэсэн учраас эрдэмтэд тус үгийг “hiluqatqu, hiluqatba, hilu’atuju”(Kuribayashi 2001:273,316), “šiluᠣᠭadhui, šiluᠣᠭадba,šiluatuju” (Tegšidügüreng,2020:174,200) гэх мэтээр галиглаж байна. “Монголын нууц товчоон”-д “шири, ширбүсүн, шилигуй-а, шихи, шир-а” зэрэг үгсийн “ши” үеийг бүр “失” үсгээр галигласан учраас §174 “ийн “喜魯中合 中忽, “喜魯中合 楊 罷” ба §188-ын “喜魯阿秃周”-ийн эхний үе нь “ши” биш гэдгийг үзэж гарна.

“iloᠣᠭа-” язгуурт үгийн нэгдүгээр үеийн хятад галиг нь “喜” болсон нь нэг талаар, дундад эртний монгол хэлэнд зарим үгийн эхний эгшгийн өмнө нь h авиатай байснаас болж, нөгөө талаар, хятад үсгийн авиа тэмдэглэх хязгаардмалаас шалтгаалагджээ. Дундад эртний монгол хэлэнд зарим үгийн эхний эгшгийн өмнө h гийгүүлэгчтэй байсан тухай эрдэмтдийн судалгаанаас гурвыг дурдвал: Гарди “дундад үе буюу түүнээс эртэвтэр үеийн зарим үгийн эхний эгшгийн өмнө h авиатай байсан ба зарим судалгааг үндэслэвэл язгууртаа p, f байсан гэж ч байдаг. Үүний улмаас эртний монгол хэлэнд “a” гэх мэтийн үгийн эхний үед эгшиг авиагаар эхэлсэн үе нь одоогоос цөөн байсан бөгөөд хожмын хөгжилтийн явцдаа нь балран гээгдсэн юм” (2008:107) хэмээн өгүүлж, Хасбагана

³ Ойгудай Манлайн сурвалжилгаар дамжин Үүшин хошууны Баянжаргал настнаас илооны тухай тус мэдээ зангийг олов. Манлай авгай ба Баянжаргал настанд гүн талархал дэвшүүлж байна

“монгол хэлний үгийн эхний бус үеийн эгшиг балархайшин гээгдэж, үгийн эхний үеийн эгшиг улмаас тод чанга авиалагдах болсон нь уулаас сулавтар авиалагдаж байсан үгийн эхний шүргэх гийгүүлэгч h гээгдэхийг нөлөөлж түргэтгэсэн байж магадгүй” (2000:49) хэмээн үгийн эхний h -ийн гээгдсэн шалтгааныг шинжилжээ. Бүрэнбат түүхэн хэл шинжлэлийн үүднээс *h-ийн хувиралтыг мөрдөн шинжилж, *h ба *p- ийг холбон шинжлээд эртний монгол хэлний “* p”-гийн хувиралт нь * p > * q ~ * k > x ~ x ба *p > *f > *h > ø (тэг) гэх хоёр загварт улирсан хэмээн үзжээ (1991:16).

“Монголын нууц товчоон”-д “喜魯^{中合}楊^{中忽}” ба “^中喜魯阿禿周”-тай адилаар “喜” үсгээр үгийн эхний үеийг галигласан үгс “хар нүднээ ирмэс (喜^舌兒^篋思) үл хийхүн тэд” (§194), “уртын үзүүрээ гүний ёроороо (喜^舌魯阿^舌刺) хүрэлцтүгэй хэмээн нэхүүлэн ” (§199) , “хар нүдээ ирмэс (喜^舌兒^篋思) үл хийн хавтгай чихээ дэр дээр үл тавин” (§254) мэтээр гурав бий. “Монголын нууц товчоон”-д “хилэн , хийвэй, хийгдэв, хиад , хитугай” зэрэг үгсийн эхний гийгүүлэгчийг “乞” үсгээр галиглаж, “илугадужу” “ирмэс ” “язгуур” зэрэг үгсийн эхний үеийг “喜” үсгээр галигласнаас үзэхэд, “Монголын нууц товчоон”-ы галиглагчдаас өмнөө h-тэй авиалагдаж байсан эгшиг ба “х” гийгүүлэгчийг адил бусаар үзэж байжээ. Гэхдээ өмнөө h-тэй авиалагдаж байсан “арван, аран” зэрэг үгсийн эхний үеийг “哈”-аар галигласан байхад харин өмнөө h-тэй авиалагддаг “и”-г “喜 ” буюу “希”⁴ үсгээр галигласны шалтгаан бол хятад үсэгт “хи” авиаг галиглах үсэг байхгүйгээс болжээ. Үүнээс үзвэл, “Монголын нууц товчоон”-ы “喜^舌兒^篋思”, “喜^舌魯阿^舌刺” зэрэг үгсийн эхний үеийг бид “и” эгшгээр буулгаж байхтай адилаар “喜魯^{中合}楊^{中忽}”, “喜魯^{中合}楊^{中忽}” ба “^中喜魯阿禿周”-гийн нэгдүгээр үеийг ч “и” хэмээн буулгах нь зохистой юм.

2. Хоёрдугаар үеийн бичлэг. “Монголын нууц товчоон”-ы §174-ийн “iloyadqu” ба “iloyadba” хоёр үгийг Лувсанданзаны “Алтан товч”-д “ялагдах ... ялагдав” (Coyima, 2017:142) хэмээн утгачлан тэмдэглэж бий.

“Монголын нууц товчоон”-д “ялагдах (§140), ялагдаа (§244), ялагдваас (§244)” зэрэг “ila” язгуурт үйл үгс тэмдэглэгдсэн бөгөөд хятад галиг нь “亦刺-” байхаас үзэхэд “ila” язгуурт үйл үг ба “iloᠣᠭa” язгуурт үгс нь “Монголын нууц товчоон”-д ялгаатай тэмдэглэгдэжээ. “Монголын нууц товчоон”-ы “喜魯^{中合}楊^{中忽}”, “喜魯^{中合}楊^{中忽}” ба “^中喜魯阿禿周”-гийн хоёрдугаар үе нь лавтай “la” биш, харин “lo” болохыг хятад галиг “魯”-аас мэдэж болно. “iloyatuᠯu” гэх үгийн хажуугийн орчуулга нь “被蠅虻咬着” ба ордос нутагт илоо гэх шавж байдаг зэрэг мэдээ зангиас “Монголын нууц товчоон”-ы “iloᠣᠭa” язгуурт үгс нь “ялаа”-тай ялгаатай биш, харин илоотой хамаатай гэдгийг үзэж гарна. “Монголын нууц товчоон”-ы хятад галиглалд “魯” үсгээр дөрөв (只 魯 阿-жолоо, §275), тав (兀 魯 思-улс, §106), долоодугаар (只^舌魯格-зүрх, §230) эгшгийг бүр галигласан учраас бид “iloᠣᠭa” язгуурт үгийн хоёрдугаар үеийн эгшгийг илоо [iloᠣᠭ-a] гэх шавжийн дуудлагатай холбоод дөрөвдүгээр эгшиг мөн хэмээн үзэж буй.

⁴ “Монголын нууц товчоон”-д үгийн эхний h-тэй авиалагддаг “i”-г “希” үсгээр галигласан үгсүүд “ирмэс (希^舌兒^篋思)” (§230) “ицэн (希^纏) ба ичив (希^扯罷)” (§244), §130 ирцүүлж (希^舌里^扯兀^勒周) (§130) зэрэг бий

3. Гуравдугаар үеийн бичлэг. Антоон Мостаэртын “Ордос монгол хэлний толь бичиг”-т “*iloᠣᠣ*” гэдэг үг байх бөгөөд тус үгийг “морин илоо, илоо хонинд орсон юм байна” (2009:384) хэмээн тайлбарлаж буй. Одоогийн “жолоо” гэж бичиж байгаа үгийг “Монголын нууц товчоон”-д “只魯阿” хэмээн гурван удаа, “只羅阿” хэмээн хоёр удаа хятад галигаар тэмдэглэснээс үзэхэд тус үгийн бичлэг нь тухайн үед “*jiloᠣ-a*” байсан нь гарцаагүй юм. Үүнийг үндэслэвэл, Мостаэртын “Ордос монгол хэлний толь бичиг”-т тэмдэглэсэн “*iloᠣᠣ*” гэх үгийг “Монголын нууц товчоон”-д “*iloᠣ-a*” хэмээн бичиж байсан байна.

Дөрөв. “*iloᠣ-a*” гэх үгийн хэлний зүйн учир: “Монголын нууц товчоон” дахь гурван “*iloᠣ-a*” язгуурт үгийн нэг нь үндсэн утгаар хэрэглэгдэж, нөгөө хоёр нь шилжсэн утгаар хэрэглэгдсэнийг нэгэнт өгүүлсэн агуулгаас олж мэднэ. Доор тус үгэнд холбогдох хэлний зүйн учир ёсыг хоёр талаас өгүүлье.

1. “i”-гийн нугарал. “Монгол хэлний түүхэн улирал хөгжлийн явц дахь үгийн эхний үеийн эгшиг дараах үеийн эгшигтээ ижилсэх үзэгдлийг ‘i-ийн нугарал’ гэж нэрлэдэг” (Qasbagana,2001:6). “i”-гийн нугарал бол монгол хэлний авианы түүхэн хувирлын нэг үзэгдэл байж, тэр нь үгийн нэгдүгээр үеийн “i” эгшиг нь дараачийн үеийнхээ уруулын буюу “i”-ээс бусад уруулын бус эгшигт нөлөөлөгдөөд уруулын буюу уруулын бус эгшиг болж хувирахыг заадаг. Жишээлбэл: мах [miq-a] (a), шээс [sigesü] (e), жороо [jiroᠣ-a] (o), чулуу [čilaᠣᠣ] (u), хөрөө [kirüᠭe] (ö), шүлс [silüsü] (ü) гэх мэт.

“i”-гийн нугаралт гурван үет үгийн адил бус эгшгүүдийн дарааллыг ажиглавал жам хуультай зүйлүүд харагддаг. Жороо *ᠵᠢᠣᠷᠣᠭ᠎ᠠ* , жолоо *ᠵᠢᠯᠠᠭ᠎ᠠ* зэрэг үгэн дэх эгшгийн дараалал нь “i+o+a (o)” байж, үгийн эхний “i” эгшиг нь нугарч, “o” эгшиг болдог. Чулуу *ᠴᠢᠯᠠᠭ᠎ᠠ* , шумуул *ᠰᠢᠮᠤᠭᠤᠯᠠ*, бялуу *ᠪᠢᠯᠠᠭ᠎ᠠ* , бяруу *ᠪᠢᠶᠠᠭ᠎ᠠ*, хяруу *ᠬᠢᠶᠠᠭ᠎ᠠ* , яруу *ᠶᠠᠷᠠᠭ᠎ᠠ* зэрэг үгэн дэх эгшгийн дараалал бол “i+a+u” байж, үгийн эхний “i” эгшиг нь нугарч, “u” буюу “æ” болдог. Үүнд бяруу *ᠪᠢᠶᠠᠭ᠎ᠠ*, хяруу *ᠬᠢᠶᠠᠭ᠎ᠠ*, яруу *ᠶᠠᠷᠠᠭ᠎ᠠ* гурван үгийн эхний “i” нь “o” болсонгүй, харин урагшилсан эгшиг “æ” болсны шалтгаан бол тэдгээрийг тус тус *ᠪᠢᠶᠠᠭ᠎ᠠ* буруу, *ᠬᠢᠶᠠᠭ᠎ᠠ* хуруу, *ᠶᠠᠷᠠᠭ᠎ᠠ* уруу гэх гурван үгтэй ялгах шаардлагаас болжээ. “Монголын нууц товчоон” дахь “*ᠵᠢᠯᠠᠭ᠎ᠠ*” гэх үгийн эгшгүүд нь яг “i+o+a” гэх бүтэцтэй учраас үгийн эхний “i” эгшиг нь нугараад “o” болох ёстой.

Үүнээс гадна, “i”-гийн нугарлын “i+o+a (o)” ба “i+a+u” хоёр бүтцэт үгсийг харьцуулахаар дамжуулан “*iloᠣ-a*” язгуурт үг ба “*ilaᠣᠣ*” үндэст үгийг харьцуулж болно. Бидний ажигласныг үндэслэвэл, “*iloᠣ-a*” язгуурт үгс сурвалж бичигт дэмий олон хэрэглэгдсэнгүй⁵, харин түүний ойролцоо бичлэгт “*ilaᠣᠣ*” үндэст үг эртний сурвалж бичгүүдэд өндөр давтамжаар илэрчээ. “*ilaᠣᠣ*” үндэст үг “Лу алтан товч”, “Цагаан түүх”, “Улаан түүх”, “Эрдэнийн товч” ба “Эрдэнэ тунамал нэрт судар оршив” зэрэг сурвалж бичигт гардаг бөгөөд онцгойлон “*ilaᠣᠣᠰᠠᠨ*” гэх хэлбэр нь “Улаан түүх” зэрэг сурвалж бичигт олонтоо илэрдэг. “*ilaᠣᠣᠰᠠᠨ*” гэх үгийг “Хорин наймт тайлбар толь”-д “Шагжамуни тэргүүтэн сайн цагийн

⁵ Үүнээс гадна, “илогу [iloᠣᠣ]” язгуурт үг “Ордос монгол хэлний толь бичиг”-т “илогу [iloᠣᠣ]”, “илогула [iloᠣᠣᠯᠠ]”, “илогурха [iloᠣᠣᠷᠠ]” хэмээн 3 удаа, “Хорин нэгт тайлбар толь”-д “илогумжитай [iloᠣᠣᠮᠵᠢᠲᠠй]” хэмээн 1 удаа гарчээ

мянган бурхдыг буюу ялгуусан хэмээгч дарсан хэмээх үг. Шимнусыг дарсан утгатай.” (Namjilma,1994:285) хэмээн тайлбарлаж байна. “ilaууsan” гэх үгийн тухай Алимаа тусгайлан шинжилж, “ ‘ялгуусан’ гэдэг үгийг ‘ёлсон’ гэж хэлдэг нь нутгийн аялгууны үзэгдэл биш, харин монгол хэлний хөгжил хувирлын дүрэм ёсоор хувирч ирсэн үг болно” (2011:65) хэмээн үзжээ.

Бид “илагуху” гэх үг бол хорчин нутгийн аялгуунд үлдэж байгаа “jɔlɔ:x” гэх үг мөн гэж Алимаатай үзэлт нэгтэй боловч тус өгүүлэлд үүнийг улам нэг алхам шинжлээд тус үг бол “iloуa” язгуурт үгийн бичлэгийн эндүүрэл мөн гэж үзэж бий. “ilaуu” үндэст үгийг эндүүрэлтэй бичлэг гэж үзсэний шалтгаан хоёр бий. Эн тэргүүнд, үг бүтээх ёсны хувьд, “ила [ila]” гэх үйл язгуурт “гу[yu]” дагаврыг залгаж тэмдэг үг буюу нэр үг бүтээж болдог боловч үүний дараа “гсан/ гсэн” гэх тэмдэг үйл үгийн дагаврыг залгаж болохгүй. Дараад, дуудлагын хувьд, “илагу [ilaуu]” гэх үгийн эгшгүүдийн дараалал нь “i+a+u” болох учраас үгийн эхний “i” эгшиг нь нугараад “u” буюу “æ” болдог, энэ нь хорчин нутгийн аялгууны “jɔlɔ:x” гэх үгтэй тохиролцохгүй. “илагу [ilaуu]” гэх үгийг “илога [iloуa]” язгуурт үгийн бичлэгийн эндүүрэл гэж үзсэний үндэслэл нь “Монголын нууц товчоон”-ы ёроор гэх үгийг “iroуar-a ᠶᠢᠷᠣᠭᠠᠷᠠ ᠠᠨᠤᠨᠠᠭᠠᠷᠠ ᠶᠢᠷᠣᠭᠠᠷᠠ” (§199) хэмээн бичсэнээс гадна бас нэг удаа “iraуur-a ᠶᠢᠷᠠᠭᠤᠷᠠ ᠠᠨᠤᠨᠠᠭᠤᠷᠠ ᠶᠢᠷᠠᠭᠤᠷᠠ” хэмээн бичсэн явдал болно. “iroуar ᠶᠢᠷᠣᠭᠠᠷᠠ” гэх үгийг “iraуur ᠶᠢᠷᠠᠭᠤᠷᠠ” гэж эндүүрэн бичсэн ёс нь “iloуaуsan ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ” гэх үгийг “ilaуuуsan ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ” хэмээн эндүүрэн бичсэнтэй адил юм. “ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ” ба “ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ” хоёр үсгийн эхний гурван үеийн эгшгийн дараалал бол “i+a+u” болох учраас “ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ, ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ, ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ”-тай адилаар үгийн эхний “i” эгшиг нь нугарч, “u” буюу “æ” болох ёстой, энэ нь тус хоёр үгийн дуудлагатай нийцэхгүй. Иймээс “ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ” ба “ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ” бол ташаа бичлэг мөн. “ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ” гэх үгийг “ᠶᠢᠯᠠᠭᠤᠰᠠᠨ” гэх үгийн эндүүрэл гэж үзэхэд хүрвэл түүнд “сан [уsan]”, “гч [үci]”, “х [qu]” зэрэг дагаврыг залгаж болох эсэхийг дараачийн агуулгад шинжилье.

2. Нэр ба үйлийн хос язгуурт үг. Зарим нэр үг нь үйл үгийн харьяат шинжтэй байж, үйл үгийн үүрэг үйлдлийг бадруулж чаддаг, ийм үгийг нэр ба үйлийн хос язгуурт үг гэдэг. Жишээлбэл, хэл, заяа, хөх, өт, шинж зэрэг үгс нь нэр үг мөн бөгөөд зарим хэлний орчинд үйл үгээр ч хэрэглэгддэг. Нэр ба үйлийн хос язгуурт үгийг шалгах баримжаа бол нэг нэр үг нь үйл үгийн хувиллаар бүрмөсөн хувилж чадах эсэх явдал болно. “Заяа” гэх нэр үгээр авч хэлбэл, тэр нь “заяах, заяажээ, заяав, заяасан ...” гэх мэтээр үйл үгийн хувиллаар бүрмөсөн хувилж чаддаг учраас тэр бол нэр ба үйлийн хос язгуурт үг мөн.

“илога [iloуa]” гэх үг “Монголын нууц товчоон”-д бүр нэр язгуураар хэрэглэгдэж, 17дугаар зууны Лувсанданзаны “Алтан товч”-д “бие бөх бөгөөс гагцыг илахуйюу. Сэтгэл бөх бөгөөс олныг илахуйюу” (Џоуima,2017:196) хэмээн үйл язгуураар хэрэглэгджээ. Эртний сурвалж бичгүүдийн “илагууу [ilaуuу]” буюу “ялгуусан [ilaууsan]” зэрэг үгсийг бид үг бүтээх ёсонд нийцэхгүй, эдгээр бол “илогауу [iloуaуu]” буюу “илогагсан [iloуaуsan]” зэрэг үгсийн бичлэгийн эндүүрэл хэмээн үзсэнийг өмнө нэгэнт өгүүлэв. Тэгвэл “илогууу [iloуaуu]” буюу “илогагсан [iloуaуsan]” нь үг бүтээх ёсонд нийцэх үү? гэвэл бидний үзэхээр “илога [iloуa]” гэх нэр язгуурт үг 13дугаар зуунд нэгэнт “халдах” буюу “дайлах”

мэтийн шилжсэн утгаар хэрэглэгдэж байснаасаа 17дугаар зуун болоход нэр ба үйлийн хос язгуурт үгээр хэрэглэгдэх болжээ. Тухайлбал, “илогаюу [iloɣayu]” буюу “илогагсан [iloɣaysan] ” зэрэг үгс нь үйл үгийн харьяат шинжтэй болсон “илога” язгуурт “юу [yu]” буюу “сан [ysan]” гэх үйл үгийн хувиллын дагаврыг залгаж үүссэн учраас эдгээр үгс нь үг бүтээх ёсонд нийцэж буй.

“илога [iloɣa]” язгуур нь нэр ба үйлийн хос язгуурт үг болохын баримт нь сурвалж бичигт байхаас гадна, “илогаху [jɔlɔ:x] ” гэх хорчин нутгийн аялгууны үгэнд ч тусгагдаж буй. Тус үг нь хорчин нутгийн аялгуунд “дийлэх”, “ялах” зэрэг үгстэй адил утгаар хэрэглэгддэгээр барахгүй, бас “чадах, хүчрэх, дарлах, доромжлох, үгүй хийх ... ” мэтийн олон зүйлийн утгыг илтгэж чаддаг. Үүгээр үл барам, “илога” гэх язгуур нь илоож [iloɣaju], илоогоод [iloɣayad], илоовол [iloɣabal], илоожээ [iloɣajeɣu]... гэх мэтээр үйл үгийн хувиллаар бүрмөсөн хувилж чаддаг. Хорчин нутгийн аялгуунд зарим үг нь нэр ба үйлийн хос язгуураар хэрэглэгддэг нь зөвхөн энэ “илога” гэх үгэнд хязгаарлагдах биш. “Юм [yauɣum-a]” гэдэг үг ч хорчин нутгийн аялгуунд “юмах, юмаад, юмбал, юмжээ ... ” гэх мэтээр үйл үгийн хувиллаар хувилж, нэр ба үйлийн хос язгуурт үгээр хэрэглэгддэг. Утгын хувьд “юм” язгуурт үйл үг нь олонх үйл үгийг бүр орлон төлөөлж, зарим үед тэр нь мэдээ зангиа зөвхөн сонсогчид зориулан битүүлэн илтгэх үед хэрэглэгдэж, зарим үед будилаантай буюу тэр даруйд нь хэлэгчийн санаанд орохгүй үйл үгийг төлөөлөн харилцаанд хэрэглэгддэг. Монгол хэлэнд “илога [iloɣa]” гэх үгнээс гадна, хорхой шавжид холбогдсон үг нь нэр ба үйлийн хос язгуурт үг болдгийн жишээ бас бий. Жишээлбэл, “өт” гэдэг нэр үг нь “өтөх , өтжээ, өтөв, өтсөн” гэх мэтээр үйл үгийн хувиллаар хувирч чаддаг. Үүнээс “илога [iloɣa]” гэх үг нь нэр ба үйлийн хос язгуурт үг болдог нь монгол хэлэнд ганцаардмал жишээ огт биш гэдгийг үзэж гарна.

Дүгнэлт

“Монголын нууц товчоон”-д “илога[jɔlɔ:]” язгуурт үг нэг зүйлд (§188) үндсэн утгаар хэрэглэгдэж, нэг зүйлд (§174) шилжсэн утгаар хэрэглэгджээ. §174 зүйлийн Ван ханы хэлсэн “ илогадху уу мэтэд илогадба. Халах уу мэтэд халхан болон хайран хөвгүүний миний хацар түр хадаасан хадуулав” гэх үг ба илоо гэх шавжийн тухай хамаа бүхий мэдээ зангиас үзэхэд, илоо бол морийг дарладаг, гэвч тэр бол морины харьцалшгүй дарлага биш, заримдаа бас илоотож болохгүй морь буюу хүн байдаг. Энэ бол “илога” язгуурт үгийн тухай хувьсангуй бодисч танилт бүхий хэрэглээ мөн. Илоо ба ялаа бол адил бус хоёр салааны шавж мөн. Илоо хүн амьтны цусыг сорж чаддагаараа ялаанаас ил тод ялгагдана.Толь бичиг ба олонх нутагт хөх түрүү ба соно гэдэг шавж ийн нэрийдэл түгээмэл байж, илоо ([jɔlɔ:]) гэдэг нэрийдэл одоо зөвхөн ордос нутагт л үлдэж буй. XIII зуунд “илога” язгуурт үгэнд шавжийг заадаг үндсэн утгатай байснаас гадна. “халдах” буюу “дайлах” мэтийн шилжсэн утга орж ирсэн боловч тэр нь “Монголын нууц товчоон”-д зөвхөн нэр язгуураар хэрэглэгджээ. Хожим нь тус үг нь хувирч хөгжөөд сурвалж бичиг ба хорчин нутгийн аялгуунд нэр ба үйлийн хос язгуурт үгээр хэрэглэгдэх болсон байна. “илога [iloɣa]” гэх үг нь үйл язгуураар хэрэглэгдэх болсон явдалд монголчуудын дарлагын соёлын ухамсар тусгагдаж буй. Амьтан голтон бүхэн өөрийнхөө дарлагатай гэж монголчууд үздэг. Монголчуудын омогшил болдог морь нь жижиг шавж – илога [iloɣ-a]-нд дарлагдан зовдгийг үзээд хүмүүс “илога [iloɣ-a]” гэх нэр үгэнд үйл үгийн шинж оруулж, тус язгуурын үйл үг нь амьтан голтонд түгээмэл хэрэглэгдэх болжээ.⁶

⁶ Тус өгүүллийг кириллээр хөрвүүлэх явцад халуун дэмжлэг үзүүлсэн ГУИС-ийн багш доктор (Ph.D)

Ном зүй

- Alima 2011. “Пайуусан” gekü ügen-ü tuqai[“Ялгуусан” гэх үгийн тухай]. *Öbür mongγul-un neyigem-ün sinjilekü uqayan*.2.
- Ardajav 2010-Аγuladai ardajav. Odoki mongγul kelen-dü seyiregүlүgsen mongγul-un niγuča tobčiyān [Одоох монгол хэлэнд сийрүүлсэн Монголын нууц товчоон], *Öbür mongγul-un soyul-un keblel-ün qoriy-a. Kökeqota*..
- Bürinbatu 1991. Yapon kelen-ü iγayur törul-ün qaričayan-u asaγudal-i subiqu ni-Yapon mongγul kelen-ü γajar-un bayiča-yin ner-e-yin qaričayulul-ača[Япон хэлний язгуур төрлийн харьцааны асуудлыг сувих нь - Япон, монгол хэлний “Газрын байц”-ын нэрийн харьцууллаас]. *Öbür mongγul-un yeke surγayuli-yin erdem sinjilgen-ü sedkül*.2.
- Garudi 2008. Dundadu erten-ü mongγul kelen-ü sudulul-un uduridqal[Дундад эртний монгол хэлний судлалын удиртгал]. *Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota*.
- Damdinsürüng 2007-С. Damdinsürüng. mongγul-un niγuča tobčiyān[Монголын нууц товчоон]. *Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota*.
- Eldendei 1986-Eldendei, Ardajav. mongγul-un niγuča tobčiyān-u seyiregүlүl tayilburi[Монголын нууц товчоон - сийрүүлэл тайлбар]. *Öbür mongγul-un surγan kümүjil-ün keblel-ün qoriy-a. Kökeqota*.
- Жүгдэрийн Лувсандорж 2014. Жүгдэрийн Лувсандорж орчуулан тайлбарласан МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО. АНТООН МОСТАЭРТ МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ. Улаанбаатар. 2014.
- Igor de Rachewiltz 2015. The Secret History of the Mongols: A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century. Leiden: Brill.
- Cleaves 1982-Francis Woodman Cleaves (trans. and ed). The Secret History of the Mongols. Boston: Harvard University Press.
- Kuribayashi 2001- Kuribayashi hitoshi, Čoyijongjab(ed.) The mongolian words and index of The Secret History of the Mongols(栗林均确精扎布編: 『元朝史』ソゴル語全単語語尾引[M], 仙台: 東北大学東北アジア研究センター.)
- Mansang 2007-Tayičiyud mansang. Sin-e-ber orčiyulju tayilburilaysan mongγul-un niγuča tobčiyān [шинээр орчуулж тайлбарласан Монголын нууц товчоон]. *Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota*.
- Mostaert 2009-Antoine Mostaert (emk.), Sonom(orč.) Ordos mongγul kelen-ü toli [Ордос монгол хэлний толь бичиг]. *Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota*.
- Murakami masatsugү 1997-Murakami masatsugү (trans. and ed). The Secret History of the Mongols.(村上正二訳注: モンゴル秘史 3[M], 東洋文庫 (294) 東京: 平凡社, 197-6.)
- Namjilma 1994-Namjilma(emk.) Qorin nayimatu tayilburi toli[Хорин наймт тайлбар толь], *Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota*. Ozawa 1997-Ozawa shigeo (trans. and ed). The Secret History of the Mongols.(小澤重男訳注: 元朝秘史 (上) [M], 東京: 岩波書店.)
- Urgunge 2001-Onon Urgunge. The Secret History of the Mongols: The Life and Times of Chinggis Khan. Richmond: Curzon Press.
- С.Мөнхсайхан 2024, С.Мөнхсайхан хөрвүүлэг хийж, удиртгал бичсэн МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО, МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО судлалын олон улсын академи. Улаанбаатар.
- Tegsidүgүreng 2020-Tegsidүgүreng, qošud čenggel, Urangua. Mongγul-un niγuča tobčiyān- sin-e sergүgelte, ariγudqal, latinčilaya, orčiyulγa jiči üges-ün kelkiyes[Монголын нууц товчоон - шинэ сэргээлт, ариутгал, латинчлал, орчуулга жич, үгсийн хэлхээс]. *Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota*.
- Qasbayana 2000. Mongγul törul-ün kelen-ü üge-yin ekin-ü h geyigүlүgči-yin tuqai[Монгол төрлийн хэлний үгийн эхний h гийгүүлэгчийн тухай], *Öbür mongγul-un baysi-yin yeke surγayuli-yin erdem sinjilgen-ü sedkül*.3.
- Qasbayana 2001. Mongγul törul-ün kele ayalun-daki “i”-yin nuγural-un ončalig sinji[Монгол төрлийн хэл аялгуун дахь “i”-гийн нугарлын онцлог шинж]. *Öbür mongγul-un baysi-yin yeke surγayuli-yin erdem sinjilgen-ü sedkül*.4.
- Čenggeltei 1999. Odoo üye-yin mongγul kelen jüi[Одоо үеийн монгол хэлний зүй (нэмэн зассан хэвлэл)]. *Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota*.

Čoyima 2017-čoyima.Š.(emk.)Lubsangdanjin-u altan tobči[Лувсанданзаны ‘Алтан товч’].Öbür mongyul-un suryan kümüjil-ün keblel-ün qoriy-a.Kökeqota
 Ш.Чоймаа 2006. Шинээр хөрвүүлж тайлбар хийсэн МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО, МУИС. Монгол Судлалын Төв МХСС. Эх бичиг-Алтай судлалын тэнхим,Улаанбаатар.
 zhā qí sī qīn 1979. měng gǔ mì shǐ xīn yì bīng zhù shì. tái běi.lián chū bǎn shì yè gōng sī. (扎奇斯钦. “蒙古秘史” 新译并注释. 台北: 联出版事业公司)
 yú dà jūn 2014. měng gǔ mì shǐ yì zhù.hū hé hào tè.nèi měng gǔ dà xué chū bǎn shè..(余大钧 “蒙古秘史” 译注. 呼和浩特. 内蒙古大学出版社.)

Abstract

There are three words rooted from “ᠢᠯᠣᠭᠠ ᠶᠢᠨ iloya” in The Secret History of the Mongols, which are “ᠢᠯᠣᠭᠠᠳᠠᠬᠤ iloyadqu” and “ᠢᠯᠣᠭᠠᠳᠤᠪᠠ iloyadba” in §174, “ᠢᠯᠣᠭᠠᠳᠤᠵᠤ iloyatuju” in §188. Scholars have different interpretations of these three characters, and to date, there is no view that associates the etymological roots of these characters with insect. The “iloyadqu” and “ iloyadba” are interpreted as “infringe”, “fight”, “stir... up”, etc., and “iloyatuju” is generally interpreted as related to the root “ᠢᠯᠣᠭᠠ ᠶᠢᠨ ilaya”. In this article, we consider that the root of the three words is “ᠢᠯᠣᠭᠠ ᠶᠢᠨ iloya” instead of “ᠢᠯᠣᠭᠠ ᠶᠢᠨ ilaya”. The “iloyatuju” in §188 is the original meaning of the word “iloya”, while the “iloyadqu” and “ iloyadba” in §174 are the extended meanings of the word . Furthermore, we consider that the roots of the words such as “ᠢᠯᠣᠭᠠᠳᠤᠵᠤ ilayuyusan” “ᠢᠯᠣᠭᠠᠳᠤᠵᠤ ilayuyçi” that appeared frequently in ancient Mongolian literature and “ᠢᠯᠣᠭᠠᠳᠤᠵᠤ iloyaxu [jɔlɔ:x]” in the Khorchin dialect are also “ᠢᠯᠣᠭᠠ ᠶᠢᠨ iloya”.

Key words: The Secret History of the Mongols; iloya-; transition of vowel I; Noun-Verb Concurrence